УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2017 оны 01 сарын 04 өдөр Дугаар А/06 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.9 дүгээр заалт "Сууц өмчлөгчдийн холбоотой холбогдох асуудлыг судлаж, түүний үйл ажиллагааг тодорхой болгон, норматив стандартыг бий болгох" Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2-17 дугаар заалт "Орон сууцны конторын үйл ажиллагааны стандартыг батлуулж, хэрэгжилтийг хангуулна" үндсэн чиглэлд тусгагдсан зорилтот ажлын хүрээнд орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхэлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, тусгай зөвшөөрөлд тусгагдсан мэргэжлийн боловсон хүчин, дуудлага хүлээн авах, барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаатай танилцаж цаашид хэрэгжүүлэх ажлын санал боловсруулах Ажлын хэсгийн удирдамжийг 1 дүгээр хавсралт, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шалгалтын ажлын үр дүн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан 2017 оны 1 дүгээр улиралд багтааж Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг /Б.Цэрэнбалжид/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2017\tushaal 2016.docx

1110300013

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2017...оны 01.....дүгээр сарын 04... өдрийн
А/06.....тушаалын ...1.....дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Зорилго: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.9 дүгээр заалт "Сууц өмчлөгчдийн холбоотой холбогдох асуудлыг судлаж, түүний үйл ажиллагааг тодорхой болгон, норматив стандартыг бий болгох" Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 2-17 дугаар заалт "Орон сууцны конторын үйл ажиллагааны стандартыг батлуулж, хэрэгжилтийг хангуулна" үндсэн чиглэлд тусгагдсан зорилтот ажлын хүрээнд орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхэлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, тусгай зөвшөөрөлд тусгагдсан мэргэжлийн боловсон хүчин, дуудлага хүлээн авах, барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж цаашид хэрэгжүүлэх ажлын санал боловсруулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулна.

Хамрах хүрээ: Нийслэлийн төвийн 6 дүүргийн орон сууц нийтийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэж буй хувийн хэвшлийн 67 байгууллага

Хугацаа: 2017 оны 01 дүгээр сарын 05-аас 01 дүгээр сарын 21-ны өдөр хүртэл

Зохион байгуулалт: Ажлын хэсэг 3 хэсэгт хуваагдаж Баруун зүүн төвийн хэсгээр хуваагдан ажил байдалтай танилцана. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба унаагаар үйлчилнэ.

Ажлын чиглэл: Орон сууц нийтийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэж буй хувийн байгууллагуудын ажилтай танилцана. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл, бүтэц бүрэлдэхүүн
- Иргэд оршин суугчдаас ирүүлсэн дуудлага хүлээн авах барагдуулахтай холбоотой үйл ажиллагаа
- Өвөлжилтийн бэлтгэл арга хэмжээ
- Ослын үед ажиллах сэлбэг материал, багаж хэрэгсэл, шуурхай зохион байгуулалтын төлөвлөгөө

Ажлын үр дүн:

1. Орон сууц нийтийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд холбогдолтой хууль эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулна.
2. Орон сууц нийтийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэж буй хувийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан мониторинг хийх болон цаашид хотоос авч хэрэгжүүлэх ажлын санал, төлөвлөгөө гарна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2017.оны 01 дүгээр сарын 04 өдрийн
А/06 тушаалын 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Б.Цэрэнбалжид	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Д.Санжмятав	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч
	Л.Батбаяр	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч
	Г.Цагаанцоож	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч
	Х.Наранбаатар	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч
	З.Очирпүрэв	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч
	Э.Чинзориг	Эрчим хүчний зохицуулах хорооны Хэрэглэгч орон нутгийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Болормаа	Эрчим хүчний зохицуулах хорооны Хэрэглэгч орон нутгийн хэлтсийн мэргэжилтэн
	А.Бат-Эрдэнэ	Эрчим хүчний зохицуулах хорооны Тусгай зөвшөөрлийн хэлтсийн мэргэжилтэн
	Л.Хишигдулам	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Тусгай зөвшөөрлийн албаны дарга
	Г.Нарантуяа	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Ус ашиглалт, ариутгах татуургын улсын байцаагч
	Ж.Ариунаа	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын албаны ахлах мэргэжилтэн
	Е.Нямсүрэн	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Тусгай зөвшөөрлийн албаны мэргэжилтэн
	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн хууль, эрх зүйн мэргэжилтэн
	Б.Эрдэнэбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн мэргэжилтэн
	О.Батмөнх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:	Д.Оюунжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн барилга хот байгуулалт, орон сууц хариуцсан мэргэжилтэн